

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Өгөгдлийн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, Болдоо Оюунтүлхүүр

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
3.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;							
1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	-	"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-г тодорхойлсон "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн бодлогын 4 тэргүүлэх чиглэлийг үргэлжлүүлнэ. Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь "ХҮН ТӨВТЭЙ" хөгжлийн үзэл санаанд нийцсэн "ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ЦОГЦЛООХ"-ыг зорьж төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэх бөгөөд тус	3-р сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар	100%

112

				<p>реформууд нь ядуурлыг бууруулахад чиглэгдэнэ. 2026 онд нэн шаардлагатай салбарын реформ, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн 14 мега төслийг эрчимжүүлж, макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, бизнесийн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог багасгах замаар ядуурлыг бууруулж, эдийн засгийн эрх чөлөөний реформыг хэрэгжүүлнэ. Олон улсад зарлагддаг, нэр хүнд бүхий индексүүдийг судалснаар тухайн орны дэлхийн улс орнуудын дунд хэрхэн эрэмбэлэгдэж, ямар үзүүлэлтээр сул байгаа, ямар үзүүлэлтээр давуу байгааг харах боломжийг олгодог. Ингэснээр ямар үзүүлэлт, цаашлаад салбар, чиглэлийг илүү анхаарч сайжруулах шаардлагатайг тодорхойлоход хэрэгцээтэй мэдээллийг олж авч болдог. Энэ хүрээнд Дэлхийн өв сангаас гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс", Дэлхийн банкны "Бизнес эрхлэх таатай орчны индекс", Транспаренси интернэйшнл байгууллагын "Авлигын төсөөллийн индекс", IMD-ийн "Дэлхийн өрсөлдөх чадварын индекс", Бертельсман сангийн "Шилжилтийн индекс", Дэлхийн банкнаас гаргадаг "Засаглалын үзүүлэлтүүд" зэргийг судалж эдийн засгийн тэргүүлэх чиглэл тодорхойлох суурь</p>	
--	--	--	--	---	--

					судалгааг хийн бизнесийн орчин, засаглал, хөдөлмөрийн зах зээлийг сайжруулах хүрээнд тэргүүлэх чиглэлд санал өгсөн болно. Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан болно. Хавсралт: 1 файл		
3.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл хийх;							
2	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Тооцоо, төсөөллийн тусгасан танилцуулгын тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	-	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө боловсруулах хүрээнд Макро эдийн засгийн нөхцөл байдал, салбаруудын өнөөгийн нөхцөл байдал, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, чиг хандлага, макро эдийн засгийн 2026 оны төсөөлөл, болзошгүй эрсдлийн тойм зэрэг тооцоо танилцуулгыг бэлтгэсэн. Улсын хөгжлийн төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаан болон байнгын хороогоор танилцуулж, 2025 оны 4 сарын 29-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хавсралт: 1 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар	100%
3	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн	Тооцоо, төсөөллийн тусгасан танилцуулгын тоо	"Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль"-ийн танилцуулгад тооцоо,	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулж	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.		төсөөллийг хүргүүлсэн.	танилцуулгыг боловсруулсан байна. /1 танилцуулга/	Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан. Хавсралт: 1 файл		
4	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	Танилцуулгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн.	2025 онд улирал бүр дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /2 танилцуулга	Макро эдийн засгийн 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 дүгээр улирал, 2025 оны 2 дугаар улирлын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, танилцуулга боловсруулахад Төсвийн сектор хэсгийн Үндэсний баялгийн сан, Төсвийн орлогын талаар тайлагнасан. Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Онцгой албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг төсвийн орлогын голлох татварын орлогууд дээр 2025 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг ашиглан дүн шинжилгээ хийж тайланд тусгасан болно. Хавсралт: 3 файл	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%
5	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана.	Хөгжүүлсэн загварын тоо	2024 онд 3 загвар хөгжүүлсэн.	Загвар хөгжүүлсэн байна. /1 загвар/	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах хүрээнд дунд хугацааны орлогын төсөөллийг хийхэд олон улсад хэрэглэгддэг аргачлалыг ашиглан төсөөлөл хийх загварыг хөгжүүлсэн. Татварын болон татварын бус орлогын төсөөллийг хийхэд шаардлагатай эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл, татварын орлогын	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					мэдрэмж болон суурь орлого зэргийг хэрхэн төсөөлөх, бусад эдийн засгийн үзүүлэлт зэргийг харгалзан үзсэн. Хавсралт: 1 файл		
3.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох							
6	Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгана.	Танилцуулгад туссан тоо	2024 онд батлагдсан бодлогын баримт бичигт эдийн засагт тохиолдож болзошгүй эрсдэлийг тодорхойлж тусгасан.	Болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна. /1 танилцуулга/	Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлон тайлан бэлтгэн монгол улсын хөгжлийн төлөвлөгөө болон дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг боловсруулахад суурь мэдээлэл болгон ашигласан. Хавсралт: 1 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
7	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	Танилцуулгын тоо	2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.	Сар бүр танилцуулга бэлтгэсэн байна. /6 танилцуулга/	Тус газраас макро эдийн засгийн сарын мэдээний танилцуулгыг боловсруулан бэлтгэж байна. Энэ хүрээнд олон нийтэд нээлттэй байдаг тоо, мэдээллийг ашиглан тооцоо, шинжилгээ хийж олон нийтэд хүргэх хувилбарыг яамны албан ёсны цахим хуудасны https://med.gov.mn/monthlyreport холбоост болон Macro channel нэртэй вайбэр суваг үүсгэн англи болон монгол хэлээр байршуулж ажиллаж байна. Мөн дотоодын байгууллагуудаас тоо, мэдээлэл нэмэлтээр авч яамны удирдлагуудад зориулсан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				<p>дэлгэрэнгүй хувилбарыг А5 хэмжээтэй товхимол болгон хэвлэж гаргадаг бөгөөд мөн адил англи, монгол хувилбараар бэлтгэж байна. Макро эдийн засгийн сарын мэдээний дээрх хоёр хувилбарт төсвийн орлого, тоо, мэдээлэлд суурилсан тооцоо, шинжилгээг танилцуулгад сар бүр оруулж ажиллаж байна. Түүнчлэн тус хэлтэс сарын мэдээний танилцуулгыг яамны цахим хуудас болон Вайбэр сувагт байршуулж олон нийтэд түгээх ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>Хавсралт: 5 файл</p>			
8	<p>Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх, голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана.</p>	<p>Мэдээллийн тоо</p>	<p>Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн</p>	<p>Тухай бүр мэдээллээр хангасан байна. /тухай бүр/</p>	<p>Гадаад худалдааны голлох тоо мэдээлэл болох экспорт, импортын өдөр тутмын мэдээлэл, хилээр орсон болон гарсан машин, дэлхийн зах зээл дээрх голлох түүхий эдийн үнэ, гадаад валютын ханшийн мэдээллийг өдөр бүр нэгдсэн системд оруулж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Нийт экспорт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын долоо хонгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажилласан. Мөн уул уурхайн биржийн өмнөх өдрийн арилжаа, дэлхийн зах зээлийн үнийн мэдээлэл, болон зарим голлох бүтээгдэхүүний экспорт, импортын тоонд дүн шинжилгээ хийж, өдөр бүрийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан.</p>	<p>1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	<p>100%</p>

3.4. Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

9	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	Тайланд ашигласан тоо	-	Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/	НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгээд байна. Гааль, И-баримтын датаг сар бүр тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирлын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Мөн өрхийн худалдан авах чадварын индекс боловсруулах зорилгоор Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран 4 дэлгүүрийн 6 барааны худалдан авалтын дүнг И-баримтын тоон мэдээлэлд үндэслэн тодорхойлж, туршилт тооцоог боловсруулаад байна. И-Баримтын микро тоон мэдээллийг ашиглан өрхүүдийн худалдан авалтын бүтээгдэхүүний бүтэцийг судлахад, тоон мэдээлэл нь задгай буюу ангилагдаагүй барааг машин сургалтын аргын тусламжтайгаар ангилж, төрөлжүүлсэн. Үүний дараа өрхүүдийн заавал хэрэглэх шаардлагатай суурь хэрэглээг тодорхойлж, мөн заавал хэрэглэх шаардлагатай биш хэдий ч тусгай зориулалтаар хэрэглэх барааг тодорхойлсон. Үүний үр дүнд	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	-----------------------	---	---	---	--	------

					<p>өрхүүдийн бараа бүтээгдэхүүний хэрэглээний чиг хандлага, хэрэглээний түвшин, авакода индекс зэрэг микро эдийн засгийн ач холбогдол бүхий нарийвчилсан дүн шинжилгээг боловсруулж, мөн үр дүнг илүү ач холбогдолтой болгох үүднээс дашбоард болгон автоматжуулсан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
10	<p>Монгол Улсын төсвийн дунд хугацааны эрсдэлийг тодорхойлж танилцуулга бэлтгэн богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгана.</p>	Танилцуулгын тоо	-	Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/	<p>Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад болон дотоод эрсдлийг тодорхойлж, төсвийн орлого, зарлага, өрийн хэмжээ болон макро эдийн засагт хэрхэн нөлөөлж болох талаар тооцоолсон. Тооцооллыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл бодлогын баримт бичгийн дэлгэрэнгүй танилцуулгад тусгасан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>	10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
<p>3.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх;</p>							
11	<p>Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг холбогдох хууль, журамд заасны дагуу олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгуулна.</p>	Хэлэлцүүлэг зохион байгуулсан тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн	-	<p>Монгол Улсын "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл"-ийн өөрчлөлтийн төсөл боловсруулахтай холбогдуулан дунд хугацааны төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах, иргэдийн санал, санаачилгыг төсөвт тусгах боломжийг бүрдүүлэх үүднээс цахим орчинд 2025 оны 8 дугаар</p>	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					сарын 05-ны өдрөөс 8 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хугацаанд нээлттэй санал, асуулга явуулж нийт 300 гаруй хариулт, 17 задгай санал хүлээн авлаа. Санал асуулгад төрийн байгууллага, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдаас ирэх оны эдийн засгийн өсөлт, инфляцыг хэрхэн хүлээлттэй байх талаар асууж Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлогын талаарх үзэл бодол, санал зөвлөмжийг авч "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл"-ийн өөрчлөлтийн төсөлд тусгасан. Хавсралт: 1 файл		
12	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль	-	Монгол Улсын төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг 33.4 их наяд төгрөг байхаар баталсан. Эдийн засгийн дээрх нөхцөл байдлын улмаас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл дэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын дүн хангагдахгүй байх эрсдэл үүссэн. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн орлогын үзүүлэлтээр тооцоо, төсөөллийг өөрчлөн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					танилцуулгад тусган ажилласан. Түүнчлэн Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд удирдлагуудыг мэдээллээр хангаж хэлтсийн хариуцсан асуудлаар шипи боловсруулж, холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Тус хууль 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан болно. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд сургалт, семинар хэлэлцүүлэгт оролцсон байх	Хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд сургалт, семинар хэлэлцүүлэгт оролцсон байх	-	Хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд сургалт, семинар хэлэлцүүлэгт оролцсон байх	Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан Дунд хугацааны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл болон өрийн шинжилгээ хийх арга, хэрэгслийн талаар сургалтанд 2025 оны 12 сарын 1 - ээс 12 сарын 5-ны өдрийн хооронд хамрагдаж, төсвийн орлогын төсөөлөл хийхэд шаардлагатай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					аргачлал, загварын талаар мэдэж, төсвийн орлогын төсөөлөл хийхэд ашиглан ажилласан. Хавсралт: 1 файл		
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх.	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх.	-	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх.	Яамнаас зохион байгуулсан дараах мэдээллийн цагт идэвхтэй хамрагдсан. Үүнд: 1. Хиймэл оюун ба хэрэглээ, түүнийг хэрхэн үр дүнтэй ашиглах 2. Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж 3. Healthy is the new cool 4. Эдийн засгийн албаны үүсэл, хөгжлийн түүх 5. Хувь хүний хөгжлийг дэмжих багаар ажиллах үр чадвар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ХЯНАСАН:

Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Лхагвабаяр Энх-Амгалан / *Увсж / 2025.12.15*

Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Өгөгдлийн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, Болдоо Оюунтүпхүүр / *Б. Оюунтүпхүүр*

Огноо: 2025.12.18

